



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 06

Номгон

Ээлжит бус хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус V хуралдааныг 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цагт Баянхонгор сумын төвд зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1 Аймгийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай

1.2 2016 оны татварын давсан орлогыг хуваарилах тухай

2. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр урьдчилан хэлэлцүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР